

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
2023 оны 08 сарын 23 өдрийн
А/... албан бичгийн хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ
8 ДУГААР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	Тайлант хугацаанд манай байгууллагад 140784.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 125159.8 мянган төгрөгийг зарцуулж 15624.7 мянган төгрөг хэмнэсэн.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 13 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	7-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Санхүүгийн төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Хяналт шалгалтын үр дүн	8 сард	Санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөгөөт 7, төлөвлөгөөт бус 3 байгууллагад нийт 10 байгууллагад хийж 287.870,8 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 11141,0 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7.212,2 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар, улсын төсөвт төвлөрүүлэхээр 12.016,8 мянган төгрөг нийт 30.370,0 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоож 18.971,3 мянган төгрөгийг зөрчилийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн. Мөн 12.224,6 мянган төгрөгийн зөрчилийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, 226.234,9 мянган төгрөгийн зөрчилийг арилгуулахаар зөвлөмж өгч ажиллалаа.. Үр дүн: Актын барагдуулалт 47,2 хувь. Нийт тогтоосон нөхөн төлбөрийн актаас 14.361,8 мянган төгрөгийн акт барагдсан, 16008.2 мянган төгрөгийн актын барагдуулах хугацаа нь болоогүй байна.
3	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	8 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Тохижилт-Сүмбэр ОНӨААТҮГ 2022, 2023.08 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна. Шалгалт 60 хувьтай үргэлжилж байна.
4	Сүмбэр сумын орон нутаг хөгжлийн сангийн үйл ажиллагаанд	Сангийн үйл ажиллагаа сайжирна	8 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023.08 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт

	санхүүгийн шалгалт хийх			шалгалт хийж байна. Шалгалт 60 хувьтай үргэлжилж байна.
5	Говьсүмбэр аймгийн Баянтал сумын ЗДТГазрын 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	8 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Баянтал сумын ЗДТГазрын 2022-2023оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт хийлээ. Шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд 3,171.1 мянган төгрөгийн 4 акт, 11,188.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн. Акт барагдуулах хугацаа болоогүй байна.
6	Боржигин чуулгын 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	8 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Боржигин чуулгын 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийхээр удирдамж батлуулан шалгалтад хамрагдах материалыг 2023 оны 08 дугаар сарын 24-ний дотор хүлээн авахаар албан тоот хүргүүлээд байна.
7	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт	Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна	8 сард	Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн хүсэлтийн дагуу нэр бүхий албан хаагчдын 2008-2023 оны 6 дугаар сар хүртлэх цалин хөлсөнд төлөвлөгөөт бус 4 хяналт шалгалт хийлээ.
8	Аймгийн ЗДТГазрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	8 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн ЗДТГазрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 20 хувьтай.
9	Тохижилт сүмбэр ОНӨААТҮГазрын шилэн дансны мэдээ оруулалтад нэг бүрчилсэн хяналт хийх	Мэдээллийн ил тод байдал сайжирна	8 сард	Тохижилт сүмбэр ОНӨААТҮГазрын 2023 оны 1-7 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтад нэг бүрчилсэн хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар нийт 568,204.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн тул зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан бичиг хүргүүлэв.
10	Баянтал сумын ХХС, ОНХС, ЗДТГазрын шилэн дансны мэдээ оруулалтад нэг бүрчилсэн хяналт хийх	Мэдээллийн ил тод байдал сайжирна	8 сард	Баянтал сумын ХХС, ОНХС, ЗДТГазрын 1-7 сарын шилэн дансны мэдээ оруулалтад нэг бүрчилсэн хяналт хийж байна. Шалгалтын явц 30 хувьтай байна.
11	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдах	8 сард	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. Эхний 7 сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 97.7 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 2.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
12	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	8 сард	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 8 мэдээ байршуулсан.

				Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд мэдээлсэн.
13	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	8 сард	Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 1 удаагийн хурлаас өгсөн 1 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Сум дундын Ойн ангийн зурвас газарт хувиарлагдсан 2014 оны талбайд мод арчилгаа, усалгааг VII/31, VIII/03, VIII/14-ны хуваарьт өдрүүд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Мод бүрийн тогоог дахин засаж, тогоолж, усалгааны үйл ажиллагааны бэлтгэл хангасан. 2. Орчны хог хаягдлыг цэвэрлэж хогийг хогийг цэгт хаясан.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор:  Л.Эрдэнэчимэг